

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02 дүгээр сарын 18-ны өдөр

дугаар 10

Дархан –Уул аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3 дахь заалтууд, Голомт банкнаас жилийн ногдол ашгийн хэмжээг 250 сая төгрөгөөс дээш олгож болохгүй гэсэн Зээлийн гэрээнд заасан нөхцөл, мөн тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ногдол ашиг олгох тухай хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг нэгж хувьцаанд 0,226 төгрөг буюу нийт 250,000,000 (хоёр зуун тавин) сая төгрөг байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК-аар дамжуулан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал /Б.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э. БАТСАЙХАН